

**“Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн” сэдэвт нийцлийн аудитын
зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

2026.02.04


Улаанбаатар хот

№	Зөвлөмжийн агуулга	Хариуцах нэгж	Биелэлт
1	“Эрдэнэс монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2025.01.27-ны өдрийн 08 дугаар тогтоол, Гүйцэтгэх захирлын А/26 дугаар тушаалаар нийт орон тоог 2-оор нэмж, 133 орон тоог баталж гүйцэтгэх удирдлагад Хяналтын менежер болон Бүтээмжийн менежерийн орон тоог нэмж, үндсэн цалинг 6.0 сая төгрөгөөр тогтоосон зөрчлийг таслан зогсоох	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс	“Эрдэнэс монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2025.12.30-ны өдрийн 146 дугаар тогтоолоор компанийн бүтцийн схемийг шинэчлэн баталсан ба уг тогтоолоор Бүтээмжийн менежер, Хяналтын менежер, Төлөвлөлт, бизнес хөгжил хариуцсан менежерийн орон тоог хассан.
2	Блюскай Эйжиа ХХК-тай түрээсийн гэрээ байгуулж, конторын зориулалттай 478 мкв талбайг түрээслэн 1мкв-ийг 66.0 мянган төгрөгөөр, 2025.03.01-ээс 80.0 мянган төгрөгөөр, мөн 2025.01.05-аас 85.1 мкв талбайг 90.3 мянган төгрөгөөр нэмж түрээсэлсэн зөрчлийг таслан зогсоож, ТӨБЗГ-ын 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 139 дүгээр тогтоолын 1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах	Санхүү, бүртгэлийн хэлтэс	<p>“Блюскай эйжиа” ХХК-д түрээсэлж буй 478 мкв талбайн түрээсийн төлбөрийн талаар 2025.08.20-ны өдрийн 01/573 дугаартай албан бичгээр хүсэлт хүргүүлэн 2026.01.01-ний өдрөөс гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, түрээсийн төлбөрийг 50.0 мянган төгрөг болгон өөрчилсөн.</p> <p>Компанийн дотоод ажлын зохион байгуулалт, хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслүүдийн суурин боловсруулалт, ТЭЗҮ ажилтай холбогдуулан уул уурхайн албаны инженерүүд төвд байрлаж ажиллах шаардлага үүссэний улмаас 2025.01.05-ны өдрөөс нэмж түрээсэлсэн 85.1 мкв талбайн түрээсийн төлбөрийг бууруулах талаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2025.08.20-ны өдрийн 01/571, Дархан төмөрлөгийн үйлдвэр ХХК-д 2025.08.20-ны өдрийн 01/572 , 2026.01.27-ны өдрийн 01/32 дугаартай албан бичгүүдийг тус тус хүргүүлээд</p>

			байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2, Засгийн газрын 2001 оны 06 сарын 20-ны өдрийн 134 дүгээр журмын хавсралтаар баталсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам"-ыг тус тус үндэслэн байгуулсан Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээнд өөрчлөлт оруулаагүй байна. 2025 онд компанийн батлагдсан төсөвт багтаан түрээсийн зардлыг зарцуулсан болно.
--	--	--	--

Хянасан: ЗУГ захирал

Биелэлт гаргасан: ЗХ дарга



О.Дагвадорж

Б.Өнөржаргал